

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2011 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2012.02.07

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 4 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 21 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 9 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 47 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэснээр 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 162 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “хоршоо” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоод, тэдгээрийн гишүүдийн тооны өөрчлөлтийг сүүлийн 6 жилийн байдлаар харуулбал:



Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй хадгаламж, зээлийн хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Он	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	Хоршоодын тоо
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179
2011	4	21	9	-	47	162

Тайлбар: 2011 онд нийт 9 хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн. Үүнээс Очир төр, Их наяд кредит, Дэлүүн бүргэд хайрхан зэрэг хоршоод түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, тусгай зөвшөөрлөө сэргээлгэх тухай хүсэлтээ Хороонд ирүүлээгүй тул хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Тонхил хөгжил

хоршооны тусгай зөвшөөрлийг 2012 оны 2 дугаар сарын хуралдаанаар хүчингүй болгох тухай танилцуулгыг боловсруулан, танилцуулж байна. Харин бусад 5 хоршооны хувьд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дуусаагүй байна.

Хадгаламж, зээлийн хоршоодоос 152 буюу нийт хадгаламж, зээлийн хоршоодын 93.8 хувь нь зохих журмын дагуу 2011 оны жилийн эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 10 буюу нийт хоршоодын 6.2 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй байна. Увс аймгийн Хяргас хас, Өгөөмөр хас зэрэг хоршоод 2011 оны жилийн эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа алдаатай ирүүлсэн тул Хороонд ирүүлсэн сүүлийн улирлын байдлаарх тайлангаар нэгтгэлд хамрууллаа.

2011 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан мэдээгээ ирүүлээгүй 10 хоршоод, тайлан мэдээ нь алдаатай ирсэн 2 хоршоо, нийт 12 хоршооноос нэгтгэлд хамруулсан санхүүгийн тайланг хугацааны хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлангийн хугацаа	ХЗХ-ны тоо	ХЗХ-дын нэрс
1	2010.II улирал	1	Солжир хөгжил
2	2010.IV улирал	1	Ижил хүлэг
3	2011.I улирал	1	Си Ди Ко
4	2011.II улирал	3	Наранхас булаг, Өгөөмөр хас, Батбаяр ар
5	2011.III улирал	6	Андагч андууд, Пенни, Хяргас хас, Тэгш таван цэн, Найдвартай хөгжил, ТДМ
Нийт		12	

Тайлбар: Ирүүлбэл зохих тайлан мэдээг ирүүлээгүй Си Ди Ко, Ижил хүлэг зэрэг хоршоодын тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн, Хяргас хас, Өгөөмөр хас хоршоодын тайлан ирсэн боловч алдаатай байснаас Хороонд ирүүлсэн сүүлийн улирлын байдлаарх тайлан мэдээгээр нь нэгтгэлд хамруулсан.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2010 оны IV улирал
1	ХЗХ-дын тоо	162	179
2	Гишүүдийн тоо	26,882	25,990
3	Нийт актив	61,899,296.7	48,802,256.4
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.8%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	41,491,100.2	34,860,950.1
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%	1.1%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	2,573,105.6	3,533,893.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	1.0%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	43,842,608.5	34,778,632.0
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.3%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	8,356,914.0	7,357,425.1
	Банкны салбарт эзлэх хувь	3.2%	3.0%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	4,833,193.9	3,859,421.3
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	1,423,433.4	452,266.3
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	350,453.9	230,586.9
11	Нийт орлого	13,381,998.6	12,505,560.7
12	Нийт зардал	11,222,081.8	11,022,662.0
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	2,159,916.8	1,482,898.7
14	Активын өгөөж /ROA/	4.4%	5.3%

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 162 хоршоодоос 71 хоршоо Улаанбаатар хотод, 91 хоршоо орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

2011 оны жилийн эцсийн байдлаарх 162 хоршоодын орон нутгийн байршлыг үзүүлбэл:



2.2 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2010 оны IV улирал
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	71	74
2	Гишүүдийн тоо	11,884	11,056
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	44.2%	42.5%
3	Нийт актив	53,581,157.4	42,058,582.4
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	86.6%	86.2%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	34,899,154.2	29,708,478.8
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	84.1%	85.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	2,068,090.5	2,956,711.1
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	80.4%	83.7%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	40,082,072.6	31,773,715.6
	<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	91.4%	91.4%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	5,819,530.0	5,215,324.1
	<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	69.6%	70.9%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	3,888,877.9	3,146,462.7
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	80.5%	81.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	1,005,322.1	66,936.8
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	11,252.5	5,915.4
11	Нийт орлого	11,058,391.2	10,569,685.7
12	Нийт зардал	9,544,426.7	9,558,718.7
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	1,513,964.5	1,010,967.1

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 71 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 44.2 хувийг, тэдгээрийн нийт актив 53,581,157.4 мянган төгрөг байгаа нь нийт активын 86.6 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 71 хоршоо нь 11,058,391.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 82.6 хувийг, харин 9,544,526.7 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 85.1 хувийг тус тус эзэлж байна.

2.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд


/мянган төгрөг/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2010 оны IV улирал
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	91	105
2	Гишүүдийн тоо	14,998	14,934
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	55.8%	57.5%
3	Нийт актив	8,318,139.4	6,743,674.0
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	13.4%	13.8%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	6,591,946.0	5,152,471.2
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	15.9%	14.8%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	505,015.0	577,182.3
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	19.6%	16.3%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	3,760,535.9	3,004,916.4
	<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	8.6%	8.6%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	2,537,383.9	2,142,101.0
	<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	30.4%	29.1%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	944,316.0	712,958.7
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	19.5%	18.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	418,111.4	385,329.5
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	339,201.4	224,671.5
11	Нийт орлого	2,323,607.4	1,935,874.9
12	Нийт зардал	1,677,655.1	1,463,943.3
13	Тухайн үеийн ашиг	645,952.3	471,931.6

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын 55.8 хувь ба тэдгээрийн нийт актив 8,318,139.4 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.4 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 91 хоршоо нь 2,323,607.4 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 17.4 хувийг, харин 1,677,655.1 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 14.9 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



2.4 Хасбанкны франчайзын гэрээтэй ажиллаж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

/мянган төгрөг/

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны IV улирал	2010 оны IV улирал
1	Хас банктай франчайзийн үйлчилгээний гэрээтэй ХЗХ-дын тоо	54	65
2	Гишүүдийн тоо	9,852	9,388
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	36.6%	36.1%
3	Нийт актив /мян.төг/	4,301,885.2	3,429,419.0
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	6.9%	7.0%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	3,398,400.8	2,663,147.0
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	8.2%	7.6%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	53,660.7	94,167.5
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	2.1%	2.7%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	1,312,542.4	937,893.7
	<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	3.0%	2.7%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	1,613,479.9	1,341,494.0
	<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	19.3%	18.2%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	600,568.0	481,932.2
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	12.4%	12.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	418,111.4	385,217.7
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	247,419.8	203,674.2
11	Нийт орлого /мян.төг/	1,272,492.1	1,073,154.5
12	Нийт зардал /мян.төг/	869,126.9	737,680.8
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	403,365.2	335,473.7

Тайлан нэгтгэх өдрийн байдлаар Хасбанктай франчайзын гэрээтэй 54 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тайлант жилд Наран ховаат, Бидний хөтөч, Баянлхам, Ландо, Дэлүүн бүргэд хайрхан хоршоо, Рашааны далай, Говийн андууд, Цогт жанчхүү, Дуурлиг оч, Арвижих хас, Өсөн дэвжих жаргалтхаан, Манхан хөгжил зэрэг франчайзын гэрээ бүхий 12 хоршоод үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадаагүй, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараалан биелүүлээгүй тул хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Тайлант жилийн эцэст Хасбанктай франчайзын гэрээтэй 54 хоршоодоос Тонхил хөгжил хоршооны тусгай зөвшөөрлийг Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар, Говийн цог хоршооны тусгай зөвшөөрлийг 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар, Хас чандмань хоршооны тусгай зөвшөөрлийг Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар тус тус 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн арга хэмжээ авсан байна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөг/

	2011.12.31		2010.12.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ОРЛОГО	12,372,797.2	92.5%	11,171,397.4	89.3%	1,201,399.8	10.8%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	11,619,580.2	86.8%	10,570,630.9	84.5%	1,048,949.3	9.9%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	145,848.1	1.1%	146,456.2	1.2%	-608.2	-0.4%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	565,272.2	4.2%	365,024.9	2.9%	200,247.3	54.9%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	3,676.8	0.0%	18,940.2	0.2%	-15,263.4	0.0%

Бусад хүүгийн орлого	38,419.9	0.3%	70,345.1	0.6%	-31,925.2	-45.4%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	650,243.5	4.9%	379,424.7	3.0%	270,818.8	71.4%
Элсэлтийн хураамж	12,212.3	0.1%	8,901.3	0.1%	3,311.0	37.2%
Гишүүний татвар	24,373.3	0.2%	22,846.3	0.2%	1,527.0	6.7%
Үйлчилгээний хураамж	139,573.2	1.0%	98,147.3	0.8%	41,426.0	42.2%
Үйл ажиллагааны бусад орлого	474,084.7	3.5%	249,529.8	2.0%	224,554.9	90.0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	358,957.9	2.7%	954,738.5	7.6%	-595,780.6	-62.4%
Торгуулийн орлого	3,078.5	0.0%	-	0.0%	3,078.5	0.0%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	33,452.5	0.2%	23,558.2	0.2%	9,894.3	42.0%
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	10,000.0	0.1%	-	0.0%	10,000.0	0.0%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	144,583.9	1.1%	618,536.8	4.9%	-473,952.9	-76.6%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	75,166.7	0.6%	42,250.9	0.3%	32,915.9	77.9%
Бусад орлого	64,738.1	0.5%	205,488.8	1.6%	-140,750.7	-68.5%
Онцгой шинжтэй орлого	27,938.1	0.2%	60,231.3	0.5%	-32,293.1	-53.6%
Ердийн бус орлого	-	0.0%	4,672.7	0.0%	-4,672.7	-100.0%
Нийт орлогын дүн	13,381,998.6	100.0%	12,505,560.7	100.0%	876,438.0	7.0%

2011 онд нийт орлогын хэмжээ 12,381,998.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 876,438.0 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар өссөн нь зээлийн хүүгийн орлого 1,201,399.8 мянган төгрөгөөр, үйл ажиллаганы бусад орлого 270,818.8 мянган төгрөгөөр өсч, үйл ажиллаганы бус орлого 595,780.6 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт нөлөөлжээ.

Орлогын бууралтыг авч үзвэл үйл ажиллагааны бус орлого хэсгийн гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оны мөн үеийн байдлаас 476,952.9 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт ихээр нөлөөлсөн. Энэ нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль багглагдаж, хадгаламж, зээлийн хоршоод гишүүдээсээ гадаад валютаар хадгаламж татан төвлөрүүлэх, гадаад валютаар гишүүддээ зээл олгохыг хориглосонтой холбоотой.

3.2 Зардлын үзүүлэлтүүд

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.12.31		2010.12.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	7,384,657.5	65.8%	6,361,025.7	60.3%	1,023,631.8	16.1%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	3,436,413.3	30.6%	2,565,060.1	24.5%	871,353.2	34.0%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүргэлх)	3,499,769.3	31.2%	3,099,564.2	30.4%	400,205.1	12.9%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жил)	291,531.1	2.6%	523,899.9	1.3%	-232,368.7	-44.4%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	121,256.3	1.1%	132,767.4	4.0%	-11,511.1	-8.7%
Бусад хүүгийн зардал	35,687.5	0.3%	39,734.2	0.1%	-4,046.7	-10.2%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	805,298.5	7.2%	1,264,954.6	9.5%	-459,656.2	-36.3%
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	516,079.4	4.6%	1,220,225.7	9.4%	-704,146.3	-57.7%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	272,869.1	2.4%	2,603.2	0.1%	270,265.9	10382.0%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	4,681.1	0.0%	40,388.6	0.0%	-35,707.5	-88.4%
Бусад эрсдэлийн зардал	11,668.8	0.1%	1,737.1	0.0%	9,931.8	571.8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,520,728.6	22.5%	2,138,383.5	21.9%	382,345.1	17.9%
Боловсон хүчний зардал	1,591,354.6	14.2%	1,301,338.1	11.7%	290,016.5	22.3%

Бусад зардал	929,374.1	8.3%	837,045.4	10.2%	92,328.7	11.0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	511,397.2	4.6%	1,258,298.1	8.3%	-746,900.9	-59.4%
Торгуулийн зардал	6,315.1	0.1%	10,218.0	0.1%	-3,902.8	-38.2%
Ногдол ашгийн зардал	11,126.3	0.1%	3,870.0	0.2%	7,256.3	187.5%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	1,378.0	0.0%	1,117.3	0.0%	260.7	23.3%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	163,843.1	1.5%	968,286.5	5.5%	-804,443.4	-83.1%
Үйл ажиллагааны бус бусад зардал	33,094.8	0.3%	30,644.2	0.3%	2,450.6	8.0%
Ердийн бус зардал	5,246.0	0.0%	129.7	0.0%	5,116.4	3945.5%
Татварын зардал	290,393.8	2.6%	244,032.5	2.2%	46,361.3	19.0%
Нийт зардлын дүн	11,222,081.8	100.0%	11,022,662.0	100.0%	199,419.8	1.8%

Тайлант жилд нийт зардлын хэмжээ 11,222,081.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 199,419.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн. Үүнд хадгаламжийн хүүгийн зардал 1,023,631.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 382,345.1 мянган төгрөгөөр өсч, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 459,656.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 746,900.9 мянган төгрөгөөр буурсан өөрчлөлт нөлөөлсөн.

3.3 Алдагдалтай ажиллаж буй хоршоод

Нийт 162 хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоос 17 хоршоо буюу 10.5 хувь нь нийт 535,813.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

д/д	Алдагдлын хэмжээ /интервалаар/	Хоршоодын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	400,000.0 мянган төгрөгөөс дээш	1	455,545.1	85.0%
2	10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	1	42,312.3	7.9%
3	5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	4	27,505.7	5.1%
4	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	4	9,473.2	1.8%
5	1,000.0 мянган төгрөг хүртэл	7	976.8	0.2%
	Нийт дүн	17	535,813.1	100.0%

Алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын 13 буюу 76,5 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн алдагдал 526,138.7 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт алдагдлын 98.2 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 4 хоршоо 9,674.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт алдагдлын 1.8 хувийг, Хасбангтай франчайзын гэрээтэй 1 хоршоо 3,337.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 34.5 хувийг эзэлж байна.

3.4 Ашигтай ажиллаж буй хоршоод

Нийт 162 хадгаламж, зээлийн хоршоодоос 145 хоршоо буюу 89.5 хувь нь нийт 2,695,729.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Үүнд:

Ашгийн хэмжээгээр ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Ашгийн хэмжээ /интервалаар/	Хоршоодын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь
1	500,000.0 мянган төгрөгөөс дээш	1	800,481.4	37.1%

2	100,000.0-500,000.0 мянган төгрөг хүртэл	4	574,535.0	26.6%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл	6	418,034.5	19.4%
4	10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	30	650,040.4	30.1%
5	5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	14	110,968.0	5.1%
6	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	45	124,411.6	5.8%
7	1,00.0 мянган төгрөг хүртэл	45	17,259.1	0.8%
8	Алдагдалтай	17	-535,813.1	-24.8%
	Нийт дүн	162	2,159,916.8	100.0%

Тайлант жилд ашигтай ажилласан 58 хоршоо Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн нийт ашгийн хэмжээ 2,040,103.1 мянган төгрөг буюу ашигтай ажиллаж байгаа хоршоодын нийт ашгийн 75,7 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 87 хоршоо 655,626.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт ашгийн 24.3 хувийг, Хасбангтай франчайзын гэрээтэй 52 хоршоо 394,310.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан хоршоодын нийт ашгийн 60.1 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын чанар

Хадгаламж, зээлийн хоршоодын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:


ҮЗҮҮЛЭЛТ	2011.12.31		2010.12.31		/мянган төгрөг/	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	60,527,952.8	97.8%	47,511,257.4	97.4%	13,016,695.4	27.4%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,066,923.8	29.2%	11,504,320.3	23.6%	6,562,603.5	57.0%
Касс дахь бэлэн мөнгө	1,885,154.2	3.0%	1,461,168.5	3.0%	423,985.8	29.0%
Банкинд байршуулсан харилцах	12,124,701.2	19.6%	6,555,960.2	13.4%	5,568,741.0	84.9%
Банкинд байршуулсан хадгаламж	4,057,068.4	6.6%	3,487,191.6	7.1%	569,876.8	16.3%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	39,313,755.5	63.5%	32,325,996.4	66.2%	6,987,759.1	21.6%
Нийт зээл	41,491,100.2	67.0%	34,860,950.1	71.4%	6,630,150.1	19.0%
Хэвийн зээл	38,032,190.4	61.4%	29,222,802.3	59.9%	8,809,388.1	30.1%
Хугацаа хэтэрсэн зээл	885,804.2	1.4%	2,104,254.4	4.3%	(1,218,450.2)	-57.9%
Чанаргүй зээл	2,573,105.6	4.2%	3,533,893.3	7.2%	(960,787.8)	-27.2%
<i>Хэвийн бус</i>	342,915.9	0.6%	883,242.8	1.8%	(540,327.0)	-61.2%
<i>Эргэлзээтэй зээл</i>	358,377.0	0.6%	838,384.2	1.7%	(480,007.2)	-57.3%
<i>Муу зээл</i>	1,871,812.7	3.0%	1,812,266.2	3.7%	59,546.4	3.3%
(Зээлийн эрсдэлийн сан)	2,177,344.7	3.5%	2,534,953.6	5.2%	(357,609.0)	-14.1%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,570,339.5	4.2%	2,940,100.0	6.0%	(369,760.5)	-12.6%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	315,279.2	0.5%	393,700.50	0.8%	(78,421.3)	-19.9%
Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрс/сан	34,431.6	0.1%	35,021.41	0.1%	(589.8)	-1.7%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,289,491.9	3.7%	2,581,420.90	5.3%	(291,929.0)	-11.3%
БУСАД ХӨРӨНГӨ	173,366.6	0.3%	184,328.8	0.4%	(10,962.2)	-5.9%
Материал үнэ бүхий зүйл	154,172.1	0.2%	119,693.7	0.2%	34,478.4	28.8%
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	11,554.9	0.0%	8,731.3	0.0%	2,823.6	32.3%
Бусад актив	7,639.5	0.0%	55,903.7	0.1%	(48,264.2)	-86.3%
ӨБУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	403,567.4	0.7%	556,511.9	1.1%	(152,944.5)	-27.5%
Өмчлөх бусад хөрөнгө	435,932.7	0.7%	640,917.3	1.3%	(204,984.6)	-32.0%
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан	32,365.3	0.1%	84,405.4	0.2%	(52,040.1)	-61.7%

2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,371,343.9	2.2%	1,290,999.1	2.6%	80,344.9	6.2%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,290,350.5	2.1%	1,202,297.2	2.5%	88,053.3	7.3%
Үндсэн хөрөнгө	1,754,519.7	2.8%	1,623,931.5	3.3%	130,588.3	8.0%
Үндсэн хөрөнгийн элэгдэл	464,169.2	0.7%	421,634.3	0.9%	42,534.9	10.1%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	80,993.4	0.1%	88,701.9	0.2%	(7,708.5)	-8.7%
Биет бус хөрөнгө	66,699.5	0.1%	22,097.0	0.0%	44,602.5	201.8%
Бусад	14,293.9	0.0%	66,604.9	0.1%	(52,311.0)	-78.5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	61,899,296.7	100.0%	48,802,256.4	100.0%	13,097,040.3	27.5%

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13,097,040.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,562,603.5 мянган төгрөгөөр, зээлийн багц 6,630,150.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Нийт зээлийн багцын муу зээлийн ангилалд ангилагдсан зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59,546.4 мянган төгрөгөөр өссөн харагдаж байгаа хэдий ч хадгаламж, зээлийн хоршоодын өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө болон зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байгаа нь зээлийн багцын чанар сайжирсантай холбоотой байна.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар харуулбал:



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	26,941,065.9	43.5%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	16,828,616.4	27.2%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	9	6,389,625.2	10.3%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	39	8,166,047.0	13.2%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	27	1,933,755.0	3.1%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	60	1,498,957.6	2.4%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	16	121,422.8	0.2%
8	5,000.0 мянган төгрөг хүргэл	5	19,807.0	0.0%
	Нийт дүн	162	61,899,296.7	100.0%

Активын төвлөрлийг ангилахад томоохон буюу активын хэмжээ хамгийн ихтэй 10 хоршооны нийт актив нь 47,257,195.02 мянган төгрөг бөгөөд нийт 162 хадгаламж, зээлийн хоршоодын нийт активын 76.3 хувийг эзэлж байна.

4.2 Зээлийн багцын чанар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:
/мянган төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.12.31	хувь	2010.12.31	хувь	ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	39,313,755.5		32,325,996.4		6,987,759.1	21.6%
Нийт зээл	41,491,100.2	100.0%	34,860,950.1	100.0%	6,630,150.1	20.5%
Хэвийн зээл	38,032,190.4	91.7%	29,222,802.3	83.8%	8,809,388.1	27.3%
Хугацаа хэтэрсэн зээл	885,804.2	2.1%	2,104,254.4	6.0%	(1,218,450.2)	-3.8%
Чанаргүй зээл	2,573,105.6	6.2%	3,533,893.3	10.1%	(960,787.8)	-3.0%
<i>Хэвийн бус</i>	342,915.9	0.8%	883,242.8	2.5%	(540,327.0)	-1.7%
<i>Эргэлзээтэй зээл</i>	358,377.0	0.9%	838,384.2	2.4%	(480,007.2)	-1.5%
<i>Муу зээл</i>	1,871,812.7	4.5%	1,812,266.2	5.2%	59,546.4	0.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	(2,177,344.7)		(2,534,953.6)		357,609.0	1.1%

Нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,630,150.1 мянган төгрөгөөр буюу 20.5 хувиар өссөн.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,218,450.2 мянган төгрөг буюу 3.8 хувиар буурсан байна. Тайлант жилд муу зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59,546.4 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч чанаргүй зээлийн хэмжээ 960,787.8 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдлийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.
/мянган төгрөг/

д/д	Зээлийн хэмжээ /интервал/	Хоршоодын тоо	Нийт зээлийн хэмжээ	Нийт зээлийн дүнд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	14,658,688.2	35.3%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	12,694,767.6	30.6%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	6	3,981,053.9	9.6%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	30	6,425,300.9	15.5%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	28	2,023,522.9	4.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	61	1,557,051.7	3.8%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	16	107,492.9	0.3%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	15	43,222.1	0.1%
	Нийт дүн	162	41,491,100.2	100.0%

Зээлийн өрийн үлдэгдлийг бүлэглэхэд ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 12 хоршооны зээлийн өрийн үлдэгдэл 31,334,509.7 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын гишүүддээ олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 75.5 хувийг эзэлж байна.

ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2011.12.31	2010.12.31	Өөрчлөлт
----------	------------	------------	----------

	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	48,709,188.9	78.7%	37,585,410.0	77.0%	11,123,778.9	338.4%
ХАДГАЛАМЖ	43,842,608.5	70.8%	34,778,632.0	71.3%	9,063,976.5	26.1%
1. Хугацаагүй	2,270,493.1	3.7%	1,335,754.8	2.7%	934,738.3	70.0%
2. Хугацаатай	41,572,115.4	67.2%	33,442,877.2	68.5%	8,129,238.2	24.3%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1,423,433.4	2.3%	452,266.3	0.9%	971,167.1	214.7%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,373,130.1	2.2%	348,439.6	0.7%	1,024,690.5	294.1%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	50,303.4	0.1%	103,826.8	0.2%	-53,523.4	-51.6%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,092,693.1	5.0%	2,123,924.7	4.4%	968,768.3	45.6%
5. Татварын төлөх өглөг	96,162.2	0.2%	92,411.1	0.2%	3,751.1	4.1%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,455,286.0	4.0%	1,926,525.7	3.9%	528,760.3	27.4%
7. Өглөг	512,040.9	0.8%	84,463.7	0.2%	427,577.2	506.2%
8. Бусад пассив	29,203.9	0.0%	20,524.2	0.0%	8,679.7	42.3%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	350,453.9	0.6%	230,586.9	0.5%	119,867.0	52.0%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	304,201.4	0.5%	230,586.9	0.5%	73,614.5	31.9%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	46,252.5			0.0%		
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	13,190,107.8	21.3%	11,216,846.5	23.0%	1,973,261.4	38.8%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	8,356,914.0	13.5%	7,357,425.1	15.1%	999,488.8	13.6%
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	8,356,914.0	13.5%	7,357,425.1	15.1%	999,488.8	13.6%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	4,833,193.9	7.8%	3,859,421.3	7.9%	973,772.5	25.2%
11. Нөөцийн сан	1,849,842.7	3.0%	1,497,637.3	3.1%	352,205.4	23.5%
12. Дахин үнэлгээний сан	269,618.9	0.4%	269,480.8	0.6%	138.0	0.1%
13. Нийгмийн хөгжлийн сан	259,627.1	0.4%	210,819.1	0.4%	48,808.0	23.2%
14. Бусад сангууд	138,581.1	0.2%	82,611.1	0.2%	55,970.0	67.8%
15. Хандив, тусламж	38,862.6	0.1%	42,985.6	0.1%	-4,123.0	-9.6%
16. Бусад өмч	19,291.6	0.0%	54,314.5	0.1%	-35,022.9	-64.5%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	2,159,916.8	3.5%	1,482,898.7	3.0%	677,018.1	45.7%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	97,453.1	0.2%	218,674.2	0.4%	-121,221.1	-55.4%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	61,899,296.7	100.0%	48,802,256.4	100.0%	13,097,040.3	26.8%

Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13,097,040.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,063,976.5 мянган төгрөгөөр, урт, богино хугацааны төслийн санхүүжилт, зээлийн дүн 1,091,034.1 мянган төгрөгөөр, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 999,488.8 мянган төгрөгөөр, хоршоологчдын өмчийн дүн 973,772.5 мянган төгрөгөөр, өр төлбөрийн дүн 968,768.3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг бүлэглэн харуулбал:


д/д	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-ны тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	21,168,149.1	48.3%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	4	13,156,049.6	30.0%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	5	3,421,975.4	7.8%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	17	3,765,452.1	8.6%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	14	1,042,017.6	2.4%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	45	1,082,147.5	2.5%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	20	149,692.0	0.3%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	32	57,125.2	0.1%
9	Хадгаламжгүй	24	0.0	0.0%

Нийт хадгаламжийн дүн	162	43,842,608.5	100.0%
-----------------------	-----	--------------	--------

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 10 хоршооны хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 37,746,174.1 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 86.1 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй нийт 24 хоршоо байгаа бөгөөд нийт хоршоодын 14.8 хувийг эзэлж, зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг графикаар харуулбал:



Тайлант жилд хувь нийлүүлсэн хөрөнгө 8,356,914.0 мянган төгрөг байна. Үүнийг интервалаар харуулбал:

д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	Хоршоодын тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	2,059,667.8	24.6%
2	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	2	1,274,889.0	15.3%
3	100,000.0-500,000.0 мянган төгрөг	10	1,649,445.4	19.7%
4	50,000.0-100,000.0 мянган төгрөг	18	1,195,642.0	14.3%
5	15,000.0-50,000.0 мянган төгрөг	55	1,591,605.8	19.0%
6	10,000.0-15,000.0 мянган төгрөг	27	329,755.3	3.9%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	25	178,253.6	2.1%
8	1,000.0-5,000.0 мянган төгрөг	24	77,655.1	0.9%
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	162	8,356,914.0	100.0%

Хадгаламж, зээлийн хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.



Харин хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмч 3,823,985.6 мянган төгрөг байгаа бөгөөд интервалаар харуулбал:

/мянган төгрөг/

д/д	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	500,000.0-2,000,000.0 мянган төгрөг	1	1,166,925.2	24.1%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	10	2,607,789.8	54.0%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	10	634,715.5	13.1%
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	28	765,666.1	15.8%
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг хүртэл	16	194,869.2	4.0%
6	1,000.0-10,000.0 мянган төгрөг	62	281,159.3	5.8%
7	100.0-1,000.0 мянган төгрөг	13	8,428.7	0.2%
8	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	22	-826,359.9	-17.1%
	Нийт дүн	162	4,833,193.9	100.0%

ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР

Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээгээр нь 4 ангилж дараах байдлаар бүлэглэсэн. Үүнд:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ-н тоо	ХЗХ-нд эзлэх хувь	Нийт активт эзлэх хувь	Үүнээс	
					УБ хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	81	50,0%	2,7%	30	51
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	66	40,7%	16,3%	30	36
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	9	5,6%	10,3%	5	4
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	6	3,7%	70,7%	6	-
	Нийт дүн	162	100.0%	100%	71	91

ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛАНГААР	
А	АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН		
1	АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	2,181,020.4	2,177,344.7 Хангаагүй
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	6.2% Хангаагүй
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0%	0.0%
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	63.5%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	0.7%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	2.1%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	70.8%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	2.7%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	13.5%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	7.8% Хангаагүй
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	724,979,080.2	1,849,842,692.7
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ		
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	4.1%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР		
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	27.0%
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)		
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		4.4%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		15.1%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		30.8%

Хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлээс харахад чанаргүй зээлийн зохистой харьцаа 5.0 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарласан боловч нийт салбарын хувьд 1.2 хувиар хэтрүүлсэн, активын эрсдэлийн санг 3,675.7 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, гишүүдийн хоршоологчдын өмчийн харьцаа нийт активын 10.0 хувиас дээш байхаар заасан боловч 2.2 хувиар дутуу зэрэг зөрчилтэй байна.

Чанаргүй зээлийн багц өмнөх оны мөн үеээс 960,787.8 мянган төгрөгөөр буурч, зээлийн багцын чанар сайжирсан хэдий ч муу зээлийн ангилалд 59,546.4 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдэж ангилагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн зохистой харьцааны хангаагүй хувь 3.9 хувиар, гишүүдийн хоршоологчдын өмчийн

хангаагүй хувь 0,1 хувиар тус тус буурсан байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2011 оны эцсийн байдлаар нийт 162 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Улаанбаатар хотод 71 хоршоо, орон нутагт 91 хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 152 буюу нийт хадгаламж, зээлийн хоршоодын 93.8 хувь нь зохих журмын дагуу 2011 оны жилийн эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 10 буюу нийт хоршоодын 6.2 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй байна.

Эдгээр тайлан мэдээгээ ирүүлээгүй хоршоодоос Си Ди Ко, Ижил хүлэг зэрэг хоршоодын тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлсэн арга хэмжээг авсан. Увс аймгийн Хяргас хас, Өгөөмөр хас зэрэг хоршоод 2011 оны жилийн эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа алдаатай ирүүлсэн тул Хороонд ирүүлсэн сүүлийн улирлын байдлаарх тайлангаар нэгтгэлд хамрууллаа.

2011 онд нийт 9 хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн. Үүнээс Очир төр, Их наяд кредит, Дэлүүн бүргэд хайрхан зэрэг хоршоод түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, тусгай зөвшөөрлөө сэргээлгэх тухай хүсэлтээ Хороонд ирүүлээгүй тул хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Тонхил хөгжил хоршооны тусгай зөвшөөрлийг 2012 оны 2 дугаар сарын хуралдаанаар хүчингүй болгох тухай танилцуулгыг боловсруулан, танилцуулж байна. Харин бусад 5 хоршооны хувьд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа дуусаагүй байна.

2011 оны эцэст 162 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2010 оны мөн үетэй харьцуулахад тооны хувьд 17-оор буурсан хэдий ч санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тодорхой хэмжээний өсөлтүүд гарч чанарын ахицтай байна. Тухайлбал:

1. Нийт актив

Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13,097,040.3 мянган төгрөгөөр буюу 27,5 хувиар өсөж, банкны салбарын 0,7 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хадгаламж, зээлийн хоршоодын хувьд дундаж активын хэмжээ 754,523.4 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж хадгаламж, зээлийн хоршооны дундаж активын хэмжээ 91,408.1 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хоршооны хувьд 186,164.2 мянган төгрөгөөр, орон нутгийн хоршооны хувьд 27,182.6 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

2. Нийт зээлийн өрийн үлдэгдэл


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,630,150.1 мянган төгрөгөөр буюу 20,5 хувиар өсөж, банкны салбарын 0,7 хувийг эзэлж байна. Нийт зээлийн багцын муу зээлийн ангилалд ангилалдсан зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59,546.4 мянган төгрөгөөр өссөн харагдаж байгаа хэдий ч хадгаламж, зээлийн хоршоодын өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө болон зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байгаа нь ерөнхийдөө чанаргүй зээлийн хэмжээ багасаж, зээлийн багцын чанар сайжирсан гэж үзэх боломжтой байна.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

Хоршоодын хадгаламжийн хэмжээ 9,063,976.5 мянган төгрөгөөр буюу 26,1 хувиар өсөж, банкны салбарын 1,2 хувийг эзэлж байна. Хадгаламжийн төрлийн хувьд авч үзвэл хугацаатай хадгаламжийн хэмжээ 8,129,238.2 мянган төгрөгөөр өссөн байна.

4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 999,488.9 мянган төгрөгөөр өсч, банкны салбарын 3,2 хувийг эзэлж байна. Сүүлийн 6 жилийн тоон мэдээллээс харахад тайлант жилд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ хамгийн ихээр өссөн байна. Үүнийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



5. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеийн байдлаас 973,772.6 мянган төгрөгөөр өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө хоршоодын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

6. Нийт орлого, ашиг

Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаа сайжирч, өргөжиж байгаатай холбоотойгоор, нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 876,437.9 мянган төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 199,419.9 мянган төгрөгөөр өссөн байна. 2011 оны жилийн эцсийн байдлаар тайлант үеийн ашиг 677,018.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 2010 оны зохицуулалт үйлчилгээний хөлс 13,030.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс жилийн эцсийн байдлаар 13,096.5 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн, нэг удаа төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлснөөс тусгай зөвшөөрлийн сунгалтын хураамж болох нийт 290,0 мянган төгрөг төлөхөөс 300,0 мянган төгрөг төлөгдсөн байна.

Аудитын тухай хуулиар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоод санхүүгийн жилийн эцсийн тайлангаа заавал баталгаажуулах үүрэгтэй. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж байгаад хяналт тавин ажиллахад хуулийн хэрэгжилт 91 хувьтай байна. Мөн 2012 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар ирүүлсэн тайлан мэдээг хянаж нийт 119 хадгаламж, зээлийн хоршоонд анхаарах болон зөвлөх зүйлийн талаар хариу бичгүүдийг хүргүүлээд байна.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай бие даасан хууль 2011 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 2011 оны 12 дугаар сард хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хадгаламж, зээлийн хоршоодод хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор анхаарах зүйлсийн талаар зөвлөмж, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй хадгаламж, зээлийн хоршоодод хуулийг хуулбарлан хүргүүлсэн.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хууль батлагдсантай холбоотойгоор хамтран ажиллах талаарх албан бичгийг хүргүүлэн ажиллаа.

Цаашид хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хадгаламж, зээлийн хоршоодын улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэг болон дүрэм, журам, заавруудад хуулийн дагуу өөрчлөлт хийлгэх, Бүх гишүүдийн хурлын баримт бичгийг хүлээн авч, хуулийн шаардлагад нийцсэн эсэхийг хянах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР